

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

**2008 оны 10 дугаар
сарын 22-ны өдөр**

дугаар 219

**Улаанбаатар
хот**

Журам шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, 34.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад орохыг хүссэн өргөдөл, үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтний анкет, үнэмлэх, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрхийн аттестатчилалд хамрагдахыг хүссэн өргөдлийн маягтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэт цаасны хорооны /хуучнаар/ 2003 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд сурталчилахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АЖИЛЛАХ МЭРГЭЖИЛТЭНД АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ ЭРХ ОЛГОХ, АТТЕСТАТЧИЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмаар үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, аттестатчилахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэн /цаашид “мэргэжилтэн” гэх/ гэж үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үндсэн чиг үүргийг гүйцэтгэх ажил эрхэлдэг, Хорооноос үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан этгээдийг хэлнэ.

1.3. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх гэж үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагыг төлөөлж үнэт цаасны зах зээлд оролцохоор Хорооноос авсан эрхийг хэлнэ.

Хоёр. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтын комисс

2.1. Шалгалтын комисс нь үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгоход шаардлагатай сургалт, шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус комисс байна.

2.2. Шалгалтын комисс нь комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдгээрийг Хорооны дарга томилно.

2.3. Шалгалтын комиссын гишүүдийн бүрэлдэхүүнд Хорооны ажлын албаны болон мэргэжлийн байгууллагын холбоод, их, дээд сургуульд үнэт цаасны чиглэлээр хичээл заадаг эрдмийн зэрэг, цолтой багш, эрдэмтдийн төлөөлөлтэй байж болох бөгөөд комиссын дарга нь Хорооны гишүүн байна.

2.4. Шалгалтын комиссын гишүүд дараах эрх, үүрэгтэй байна:

2.5.1. Шалгалтын асуулт, тестийг бусдаар бөглүүлэх, хуулах зэрэг үйлдэл хийсэн оролцогчдыг протоколд тэмдэглэж, шалгалтаас хасах;

2.5.2. Шалгалтын тест болон асуултын нууцыг чанд хадгалах;

2.5.3. Шалгалтын комиссын үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцох;

2.5.4. Шалгалтын дүнг Хороонд танилцуулах.

2.5 Шалгалтын комисс нь энэ журамд заасан шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

2.6. Шалгалтын комиссын нарийн бичгийн даргын үүргийг Хорооны үнэт цаасны зах зээлийн зохицуулалт хариуцсан нэгжийн мэргэжлийн сургалт хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

2.7. Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй:

2.7.1. Шалгалтад хамрагдахаар өргөдөл гаргасан этгээдийн бичиг, баримтыг энэхүү журамд нийцүүлэн хүлээн авч бүртгэх;

2.7.2. Шалгалтад орохоор өргөдөл гаргасан этгээдэд Хорооны цахим хуудас, бусад арга хэрэгслээр шалгалт, сургалтын товын зар хүргэх;

2.7.3. Шалгалтыг зохион байгуулах;

2.7.4. Шалгалт болон шалгалтын комиссын хуралдааны тэмдэглэл хөтөлж, баримт бичгийг цэгцлэн Хорооны архивт шилжүүлэх.

2.8. Энэхүү журмын 3.1 дэх заалтын дагуу шалгалтын комисс сургалтыг зохион байгуулах бол шалгалтын комиссын нарийн бичгийн дарга 2.7.1 –ээс 2.7.4 дэх заалтад заасан эрх, үүргийг сургалтын хувьд нэгэн адил хэрэгжүүлнэ.

2.9. Хорооны Тамгын газрын тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан нь мэргэжилтнүүдэд эрх олгосон, түдгэлзүүлсэн, цуцалсан, аттестатчилсан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөнө.

Гурав. Сургалт зохион байгуулах

3.1. Хороо сургалт зохион байгуулах эрхийг сургалт зохион байгуулах шаардлага хангасан их, дээд сургууль, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагад шилжүүлснээс бусад тохиолдолд шалгалтын комисс нь сургалтыг зохион байгуулна.

3.2. Сургалт явуулах, шалгалт авах өдрөөс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө шалгалтанд орохоор өргөдөл гаргасан этгээдэд Хорооны цахим хуудас, бусад арга хэрэгслээр зар хүргэнэ.

3.3. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авах сургалтад оролцох этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1 Эрх зүйн чадамжтай;

3.3.2. Эдийн засаг, санхүү, эрх зүйн чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй;

3.3.3. Энэхүү журмын 3.3.2-т заасан шаардлагыг хангаагүй боловч бусад мэргэжлээр бакалаврын зэрэг авсан этгээд нь үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг олгох анхан шатны бусад сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан;

3.3.4. Сүүлийн 2 жилийн хугацаанд мэргэжлийн алдаанаас болж дампуурсан, хууль тогтоомж зөрчсөний улмаас тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон мэргэжлийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлж байгаагүй;

3.3.5. Зохих төлбөр төлсөн.

3.4. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтад оролцох этгээд нь 2 дугаар хавсралтын “Маягт-1”-ын дагуу өргөдөл, “Маягт-2”-ын дагуу анкетыг бөглөн 3.3.2-аас 3.3.5-т заасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримтын хамт бүрдүүлж бүртгүүлнэ.

3.5. Сургалт нь 90-ээс доошгүй цаг байх бөгөөд үнэт цаастай холбоотой эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн зохицуулалтын гүнзгийрүүлсэн сэдэв, агуулгатай байна.

3.6. Сургалтыг техник, тоног төхөөрөмжийн шаардлага хангасан, тараах материал сургалтад оролцогч бүрт хүртээмжтэй байхаар зохион байгуулна.

3.7. Шалгалтын комисс 80-аас доошгүй цагийн сургалтыг хангасан этгээдээс үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалт авах шийдвэрийг гаргана.

3.8 Сургалтын төлбөрийн хэмжээг Хороо тогтооно.

Дөрөв. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох

4.1. Сургалтын цаг хангасан этгээдээс үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалт авна.

4.2. Шалгалтыг хоёр шаттайгаар авах бөгөөд эхний шатыг тестээр, хоёрдугаар шатыг ярилцлагын хэлбэрээр авна.

4.3. Шалгалтын тестийг боловсруулах ажлыг шалгалтын комиссын шийдвэрээр томилогдсон гишүүн хариуцан нэгтгэн боловсруулж шалгалтын комиссын хурлаар батлуулна.

4.6. Тестийг битүүмжилсэн байдлаар шалгалт авах танхимд хүргэж уг танхимд задална.

4.7. Тухайн тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулсан этгээд шалгалтын хоёрдугаар шатанд орох эрхтэй болно.

4.8. Тестийн хариуг эхний шатны шалгалтын дараа задлах бөгөөд шалгалтын комисс нь шалгалт өгсөн этгээдийг өөрийн тест бөглөсөн байдалтай танилцах боломжоор хангана.

4.9. Шалгалтын хоёрдугаар шатад тэнцсэн этгээдэд шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн Хороо 3 жилийн хугацаатайгаар эрх олгоно.

4.10. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэхийг 2 дугаар хавсралтын “маягт-3”-ын дагуу үйлдэнэ.

4.11. Шалгалтын төлбөрийн хэмжээг Хороо тогтооно.

Тав. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхтэй мэргэжилтэнг аттестатчилах

5.1. Мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө Хороонд хандаж аттестатчилалд хамрагдах өргөдлийг 2 дугаар хавсралтын “Маягт-4”-ын дагуу гаргана.

5.2. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, эрх авсан хүмүүсийг давтан сургалтанд хамруулж аттестатчилах ажлыг шалгалтын комисс зохион байгуулна.

5.3. Шалгалтын комисс жилд 2-оос доошгүй удаа давтан сургалт, аттестатчилах шалгалтыг зохион байгуулж үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн хугацаа дуусах гэж буй, аттестатчилалд хамрагдах өргөдөл гаргасан мэргэжилтнүүдийг хамруулна.

5.4. Давтан сургалтыг Хороо эсвэл түүний эрх олгосноор үнэт цаасны зах зээлийн талаарх сургалт зохион байгуулах шаардлага хангасан их, дээд сургууль, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага зохион байгуулж болно.

5.5. Давтан сургалт зохион байгуулах тухай зарыг Хорооны цахим хуудас, бусад хэрэгслээр дамжуулан ажлын 10 хоногийн өмнө өргөдөл гаргасан мэргэжилтнүүдэд мэдээлнэ.

5.6. Сургалт нь 40 цаг байх бөгөөд аттестатчилалд хамрагдах мэргэжилтэн нь 30-аас доошгүй цагийн сургалтад хамрагдсан байна.

5.7. Шалгалтын комисс нь энэхүү журмын 5.6-д заасан шаардлага хангасан этгээдийн талаар зохих шийдвэр гаргаж шалгалтад оруулна.

5.8. Шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн аттестатчилах шалгалтад тэнцээгүй мэргэжилтний эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргана.

5.9. Аттестатчилах шалгалтад тэнцээгүй буюу оролцоогүй мэргэжилтэн нь энэ журмын 3.7-д заасан шаардлагыг хангасны үндсэн дээр үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтад орж болно.

5.10. Хороо дараах тохиолдолд мэргэжилтнийг хугацаанаас нь өмнө дахин аттестатчилалд орохыг шаардаж болно:

5.10.1. түүний харьяалагддаг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллага нь дахин шалгалтанд оруулах үндэслэл бүхий хүсэлт гаргасан;

5.10.2. мэргэжилтний үйл ажиллагаатай холбогдуулж харилцагчдаас үндэслэл бүхий гомдол гаргасан;

5.10.3. Хорооноос томилогдсон шалгалтын ажлын хэсэг мэргэжилтний мэргэжлийн мэдлэг, ажлын хариуцлага нь шаардлага хангахгүй байгаа гэсэн дүгнэлт гаргасан.

Зургаа. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

6.1. Дараах тохиолдолд Хороо үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг 2 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

6.1.1. Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл гаргасны дагуу шалгалт хийж, түр түдгэлзүүлэх үндэслэл байгааг тогтоосон;

6.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн.

6.2. Дараах тохиолдолд Хороо үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг хүчингүй болгоно:

6.2.1 мэргэжилтэн эдийн засгийн эсрэг гэмт хэрэг үйлдэж, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

6.2.2. үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг удаа дараа болон ноцтойгоор зөрчсөн нь тогтоогдсон;

6.2.3. мэргэжилтэн нь Хороонд өөрийн талаар худал мэдээлэл өгсөн;

6.2.4. Эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй;

6.2.5. Хорооноос зохион байгуулсан аттестатчилах шалгалтанд оролцоогүй.


6.3. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан Хорооны цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд мэдээлнэ.

6.4. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх нь хүчингүй болсон мэргэжилтэн эрүүгийн болон захиргааны шийтгэлтэйд тооцогдох хугацаа дууссаны дараа энэ журмын 3.7-д заасан шаардлагыг хангасны үндсэн дээр үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтад орж болно.

6.5. Мэргэжилтэн Хорооноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

-- ооОоо --

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АЖИЛЛАХ
МЭРГЭЖИЛТНИЙ АНКЕТ**



Иргэний үнэмлэхийн дугаар	
Регистрийн дугаар	

Овог нэр	Төрсөн он/сар/өдөр
----------	--------------------

ОДООГИЙН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ажиллаж буй албан байгууллагын нэр	
Ямар алба/хэлтэс болох Албан тушаал	
Ажлын болон гар утас	
Факс	
Е-мэйл хаяг	

ӨМНӨ НЬ ЭРХЭЛЖ БАЙСАН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Ажиллаж байсан албан байгууллагын нэр			
Ямар ажил эрхэлж байсан			
Ажилласан хугацаа оноос он хүртэл оноос он хүртэл оноос он хүртэл

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

Төгссөн сургуулийн нэр		
Эзэмшсэн мэргэжил		
Эрдмийн зэрэг цол		
Төгссөн он		

УРАГ ТӨРЛИЙН БАЙДАЛ

Овог нэр	Таны юу болох	Төрсөн он	Одоо эрхэлж байгаа ажил/ сургууль

Дээрх мэдээллийг үнэн зөв бичсэн /гарын үсэг/

2007 оны сарын өдөр

ҮНЭМЛЭХ

----- овогтой -----

Санхүүгийн зохицуулах хорооны 20.. оны ... дугаар сарын ..-ний өдрийн ... дугаар тогтоолыг үндэслэн 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл Монгол улсын үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрхийн үнэмлэх олгов.

Дарга ----- / _____ /

20.. оны ... сарын ...-ны өдөр

20... оны ..дугаар сарын ...-ны өдрийг хүртэл аттестатчилав.

20... оны ..дугаар сарын ...-ны өдрийг хүртэл аттестатчилав.

Дарга ----- / _____ /

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ЭРХИЙН АТТЕСТАТЧИЛАЛД ХАМРАГДАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо :
Хаана: Санхүүгийн зохицуулах хороо
Засгийн газрын IV байр
Бага тойруу -6
Улаанбаатар -210646
Монгол улс

Хэнээс: овогтой Регистрийн дугаар:
.....

Миний бие үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрхийн аттестатчилалын сургалт, шалгалтад оролцохоор хүсэлт гаргаж байна.

Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад оролцохоор бүрдүүлж хүргүүлсэн бичиг баримтуудад

өөрчлөлт ороогүй.

өөрчлөлт орсон тул үнэн зөв бүрдүүлж хавсаргав. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг миний бие хүлээнэ.

Иймд өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянаж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрхийн аттестатчилалын сургалт, шалгалтад оролцуулна уу.

Миний бие Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж ажиллах болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/. / / / / гарын үсэг / овог, нэр /

/Байнга оршин суух хаяг...../